

“ДЭЛХИЙН МОНГОЛЧУУД-II” ЦОГЦ АРГА ХЭМЖЭЭ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. “Дэлхийн монголчууд” гэдэг ойлголтыг өргөн утгаар нь “хилийн чанад дахь монголчууд” гэж, үүний дотор Монгол Улсын гадаадад амьдарч буй иргэдийг “хилийн чанад дахь монгол иргэд” гэж тодорхойлж байна.

2. Суугуул газрынхаа хэл соёлд автах, эх хэлээ мартах үйл явц тургесэж байна. Хилийн чанад дахь нийт монголчуудын татагдах хүчний төв нь Монгол Улс байх тул тэдний үр сад, хойч үе үндэсний зан заншлаа хадгалж үлдэхэд монгол тэр тодорхой үүрэг хариуцлага хүлээх ёстой, энэ үүргийг дэс дараалалтай үйл ажиллагаа болгон төлөвлөж хэрэгжүүлэх явдал энэхүү цогц арга хэмжээний зорилго болно.

3. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “монгол үндэстний оршин тогтонохын үндэс, амин чухал дархлаа нь үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж хөгжүүлэх”, “үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааны эх үндэс нь эх оронч үндэсний үзэл, улс, үндэснийхээ ирээдүйн сайн сайхны төлөө хувь нэмрээ оруулахыг эрмэлзсэн идэвхтэй үйл ажиллагаа” гэж тодорхойлсон, мөн “Монголын түүх, хэл, соёл, шашин, зан заншлыг хамгаалах, хөгжүүлэх, судлах ажлыг тэр ивээлдээ авна” гэж заасан.

4. Монгол Улсын “Гадаад бодлогын үзэл баримтлал”, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод хилийн чанад дахь монголчуудад хэл соёлоо хадгалж үлдэхэд дэмжлэг үзүүлэх тухай туссан. Мөн Монгол Улсын “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Дэлхийн монголчууд-II” арга хэмжээг төлөвлөн боловсруулж хэрэгжүүлнэ” гэж заасан. Тодруулбал,

4.1. УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 1.1.6-д “Үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж хөгжүүлэх нь монгол үндэстний оршин тогтонохын үндэс, амин чухал дархлаа мөн”, 1.2.1-д “Монгол Улсын иргэн бүрийн үндэсний үнэт зүйлээрээ бахархагч, тэдгээрийг хайрлан хамгаалагч, тээн хөгжүүлэгч байх эх оронч үндэсний үзэл, улс, үндэснийхээ ирээдүйн сайн сайхны төлөө хувь нэмрээ оруулахыг эрмэлзсэн идэвхтэй үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааны эх үндэс болно”, 3.1.3.2-т “Гадаадад сурч, хөдөлмерлэж байгаа иргэддээ эх орондоо эргэн ирж ажиллаж, амьдрах таатай нөхцөл, боломжийг бүрдүүлнэ”, 3.1.3.3-т “Гадаадад төрж тухайн улсын иргэний харьяалалтай болсон иргэд, тэдний үр хүүхдэд Монгол Улсад зорчих, оршин суух, суралцах, ажиллаж амьдрах, даатгалд хамрагдах таатай нөхцөлийг бүрдүүлнэ”, 3.1.4.1-д “Монголын түүх, хэл, соёл, шашин, зан заншлыг хамгаалах, хөгжүүлэх, судлах ажлыг тэр ивээлдээ авна”, 3.1.4.6-д “Дэлхийн бусад орон, түүний дотор гуравдагч хөрш орнуудтай соёлын салбарт өргөн харилцаа хөгжүүлж, дипломат төлөөлөл,

иргэдээрээ дамжуулан монгол үндэстний соёл, түүхийг дэлхий дахинаа сурталчлах ажлыг эрчимжүүлнэ" гэж тус тус заасан.

4.2. УИХ-ын 2011 оны 10 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын "Гадаад бодлогын үзэл баримтлал"-ын 23.5-д "Олон улсад монгол судлал өргөжин хөгжихийг дэмжиж, гадаадад монгол судлалын төв байгуулахад туслалцаа үзүүлэх", 25.5-д "Бусад улс дахь монгол туургатнуудтай харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлж, хэл, соёл, уламжлалаа хадгалан хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх", 27.3-т "Иргэд гадаадад зорчих эрх зүйн таатай нөхцөл бүрдүүлэхийг эрмэлзэхийн зэрэгцээ тэд эх орондоо эргэн ирж, хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулахыг дэмжсэн бодлого хэрэгжүүлэхэд түлхэц үзүүлэх", 27.4-т "Гадаадад гэрээгээр ажиллаж байгаа иргэдийнхээ нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлээр тухайн улстай хамтран ажиллах", 27.8-д "Гадаадад буй иргэдийн үүсгэл санаачилгын байгууллага, холбоодын үйл ажиллагааг дэмжиж ажиллах", 29.2-т "Монголын түүх, байгаль, зан заншил, ахуй амьдрал, хөгжил дэвшлийг харуулсан сурталчилгааны ном, товхимол, нэвтрүүлэг, кино, цомог зэргийг бэлтгэн бусад улс түмэнд түгээх, сурталчлах" гэж заасан.

4.3. УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 1.5 дахь зорилт нь "Дэлхий дахинд монгол үндэсний үнэт зүйлсийн дархлаа тогтох, монгол соёлыг түгээн дэлгэрүүлж, гадаад нэр хүнд, үнэлээмжийг дээшлүүлж, хилийн чанад дахь монголчууд, монгол угсаатны хамтын ажиллагаа төлөвшинэ". 2 дугаар хавсралтаар баталсан 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 1.5.7-д "Хилийн чанад дахь монгол иргэдийг ёв соёлоо хадгалж хамгаалахад нь дэмжлэг үзүүлэх, монгол хэл, соёлын агуулга бүхий сурх бичиг, ном товхимол, цахим агуулга, бүтээлүүд бий болгон түгээх, монгол иргэд болон монгол төрийн харилцаа, хамтын ажиллагааг дэмжсэн "Дэлхийн монголчууд" арга хэмжээг үндэсний хэмжээнд хэрэгжүүлнэ", 1.5.8-д "Дэлхийн монгол туургатнуудад нүүдлийн соёл, уламжлалаа хадгалж үлдэх, ахуй соёлын онцлог, нийтлэг болон ялгаатай байдлыг харьцуулан судлах, чуулга, уулзалт, фестиваль хамтран зохион байгуулах чиглэлээр "Монгол туургатны хэл, соёл, уламжлалыг хадгалж хөгжүүлэх" хөтөлбөр хэрэгжүүлнэ", 1.5.9-д "Хилийн чанад дахь монгол соёлын ёвийг сурвалжлан олох, судлах, нэгдсэн каталог хийх, эх орондоо эргүүлэн залах чиглэлээр бусад улс оронд идэвхтэй хамтран ажиллана", 1.5.10-д "Хилийн чанад дахь монголчууд, монгол угсаатнуудын оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлж, хэл, соёл, уламжлалаа хадгалан хөгжүүлэхэд нь дэмжих чиглэлээр монгол хэл, соёлын сургалт, хөтөлбөрийг бий болгон хэрэгжүүлнэ" гэж заасан.

5. Цогц арга хэмжээ нь хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэд болон монгол туургатнуудыг хамарна.

Хоёр. Зорилго, зорилт

2.1. Цогц арга хэмжээний зорилго, зорилт нь "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 1.5-д болон Монгол Улсын "Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.5.10-д заасан зорилтуудад үндэслэнэ.

2.2. Цогц арга хэмжээний зорилго нь хилийн чанад дахь Монгол Улсын иргэдийн эрх ашгийг хамгаалах, хилийн чанад дахь монгол хүүхдийг эх хэлээ сурх

боловжоор хангах, цахим сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх, Монгол хэл, соёлын төвүүд, Монголчуудын холбоодын үйл ажиллагааг дэмжих, монгол туургатнуудтай харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, эх хэл, өв соёл, зан заншил, уламжлалаа хадгалж хамгаалахад нь дэмжлэг үзүүлэхэд оршино.

2.3. Цогц арга хэмжээний зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлнэ:

2.3.1. хилийн чанад дахь Монгол Улсын иргэдийн эрх ашгийг хамгаалах, эрх зүйн орчинг боловсронгуй болгоно;

2.3.2. хилийн чанад дахь Монгол Улсын иргэдийг цахим бүртгэлд хамруулж, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлнэ;

2.3.3. хилийн чанад дахь Монгол Улсын иргэдийн хүүхдүүдэд чиглэсэн цахим сургалтын хөтөлбөр хэрэгжүүлж, тэдний эх хэлээ суралцах боломжийг бүрдүүлнэ;

2.3.4. монгол судлалыг олон улсын болон бус нутгийн хүрээнд өргөжүүлэх, сурталчлан таниулах, монгол судлалын үйл ажиллагааг идэвхижүүлэхэд дэмжлэг үзүүлнэ;

2.3.5. хилийн чанад дахь Монголын соёлын өвийг хадгалан хамгаалах, уламжлалт соёлоо дэлхий нийтэд сурталчлан таниулна;

2.3.6. хилийн чанад дахь Монгол Улсын иргэд, монголчуудын холбоодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, соёл, урлаг, спорт, эрдэм шинжилгээний арга хэмжээг хамтран зохион байгуулна;

2.3.7. монгол туургатнуудтай харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, үндэсний хэл, соёл, өв уламжлалаа хадгалахад дэмжлэг үзүүлнэ.

Гурав. Баримтлах зарчим

3.1. Цогц арга хэмжээг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

3.1.1. Монгол Улсын Үндсэн хууль болон Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал зэрэг бодлогын баримт бичиг болон Монгол Улсын олон улсын гэрээнд тусгагдсан зарчимд нийцсэн байх;

3.1.2. үндэсний эв нэгдлийг хангах, ардчилсан ёс, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, тэгш байдал, ил тод байдал, хууль дээдлэх зарчимд нийцсэн байх;

3.1.3. төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн харилцан уялдаатай хамтын ажиллагааг хангасан байх;

3.1.4. хилийн чанад дахь Монгол Улсын иргэд, монгол туургатнуудын оролцоог хангасан байх;

3.1.5. Цогц арга хэмжээний хэрэгжилтийг үр ашигтай, хэмнэлттэй зохион байгуулах, ил тод байх.

Дөрөв. Хэрэгжүүлэх хугацаа

4.1. Цогц арга хэмжээг 2021-2024 онд хэрэгжүүлнэ.

Тав. Хэрэгжүүлэх арга хэмжээ

5.1 Хилийн чанад дахь Монгол Улсын иргэдийн эрх ашгийг хамгаалах, эрх зүйн орчинг боловсронгуй болгох зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

5.1.1. хилийн чанадад монгол эцэг, эхээс төрж, гадаад улсын харьяат болсон монгол хүн эх орондоо зорчих, оршин суух таатай нөхцлийг бурдуулэх;

5.1.2. Монгол Улсын иргэнийхээ харьяаллаа сэргээн тогтоолгоход шаардагдах баримт бичгийг хялбаршуулах;

5.1.3. хилийн чанадад оршин суугаа болон хөдөлмөр эрхэлж буй иргэдийн тухайн улсад ажиллаж шимтгэл төлсөн хугацааг нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах хэлэлцээр байгуулах замаар хоёр улсаас тэтгэвэр, тэтгэмж авах эрхийг бурдуулэх чиглэлээр ажиллах;

5.2. Хилийн чанад дахь Монгол Улсын иргэдийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах, цахим бүртгэлд хамруулах үүднээс дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

5.2.1. иргэний улсын бүртгэл болон улсын хил нэвтэрсэн бүртгэлд тулгуурлан хилийн чанад дахь Монгол Улсын иргэдийн нэгдсэн бүртгэлийн цахим санг бүрдүүлэх;

5.2.2. хилийн чанад дахь Монгол Улсын иргэдийг дараах байдлаар ангилж бүртгэлжүүлэх;

- а) байнга оршин суугаа иргэд,
- б) оюутан сурагчид,
- в) хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэд,
- г) бусад.

5.3. Хилийн чанад дахь Монгол Улсын иргэдийн хүүхдүүдийн мэдлэгийг дээшлүүлэх, эх хэлээ сурх боломжоор хангах, цахим сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

5.3.1. хилийн чанад дахь Монгол Улсын иргэдийн хүүхдэд зориулсан монгол хэл, бичиг, түүх, соёл, өв уламжлалын талаарх цахим платформыг хөгжүүлэх, цахим сургалт зохион байгуулах;

5.3.2. Монгол хэл, соёлын төвүүдийн үйл ажиллагааг дэмжих, багш нарын заах арга зүй, мэдлэг чадварыг нь дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

5.3.3. хилийн чанад дахь Монгол хэл, соёлын төвүүдийн үйл ажиллагааг сурталчлах, харилцан туршлага солилцох чиглэлээр дэмжлэг үзүүлэх.

5.4. Монгол судлалыг олон улсын болон бус нутгийн хүрээнд өргөжүүлэх, сурталчлан таниулах, монгол судлалын үйл ажиллагааг идэвхижүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

5.4.1. Америк, Европ, Ази тивд тус бүр нэг төвийн үйл ажиллагааг бодлогоор дэмжиж, ном товхимолоор хангах, эрдэмтэн судлаачдын бүтээлд урамшуулал олгох тогтолцоог бүрдүүлэх;

5.4.2. залуу монголч эрдэмтдийн зуны сургалт, Олон улсын монгол судлалын холбооны их хурлыг зохион байгуулах;

5.4.3. Монгол судлаачдын эрдэм шинжилгээний бүтээлийг гадаадын хүлээн зөвшөөрөгдсөн эрдэм шинжилгээний ном, сэтгүүлд хэвлүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

5.5. Хилийн чанад дахь Монголын соёлын өвийг хадгалан хамгаалах, уламжлалт соёлоо дэлхий нийтэд сурталчлан таниулах зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

5.5.1. соёлын өв, түүхийн дурсгалт зүйлсийн ном товхимол, каталогийг гаргах, цахим мэдээллийн санг бий болгох, түгээх чиглэлээр ажиллах;

5.5.2. соёлын өвийг хилийн чанадад сурталчлан таниулах, эрдэм шинжилгээний хурал, семинар, үзэсгэлэн зохион байгуулах;

5.5.3. соёлын өвүүдийн талаар цахим бүтээгдэхүүн бүтээж, түгээх.

5.6. Хилийн чанад дахь Монгол Улсын иргэд, Монголчуудын холбоодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, соёл, урлаг, спорт, эрдэм шинжилгээний арга хэмжээг хамтран зохион байгуулах зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

5.6.1. хилийн чанад дахь Монгол Улсын иргэд, Монголчуудын холбоотой хамтран "Миний Монгол наадам", "Хилийн чанад дахь монголчуудын чуулга уулзалт", "Хилийн чанад дахь оюутан залуучуудын чуулга уулзалт" болон соёл, урлаг, спортын арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

5.6.2. Монгол Улсын иргэдийн улсынхаа эдийн засаг, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах боломжийг бүрдүүлэх хүрээнд "Монгол орны хөгжилд" чуулга уулзалт, "Хөдөлмөрийн форум" үзэсгэлэн, "Оюутан дадлага" арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

5.7. Монгол туургатнуудтай харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, үндэсний хэл, соёл, өв уламжлалаа хадгалан хамгаалахад дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

5.7.1. монгол туургатнуудтай хамтран "Монгол туургатны их наадам", "Алтаргана", "Дэлхийн монгол туургатан хүүхдийн их наадам" зэрэг соёл, урлагийн арга хэмжээ, эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах, оролцоог хангах, судалгааны төсөл хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

5.7.2. дэлхийн монгол түүргатнуудын үндэсний хэл, нүүдлийн соёл, зан заншил, уламжлалаа хадгалан хөгжүүлэх, монгол хэл, бичгийн цахим сургалт, хэрэглэгдэхүүнийг бий болгоход дэмжлэг үзүүлэх;

5.7.3 устах эрсдэлд ороод байгаа монгол угсаатнуудын хэл, тэдгээрийн нутгийн аялгуу, аман аялгууг баримтжуулах, судлах, сурталчлах болон тэдгээрийн хэрэглээг идэвхжүүлэх, хадгалахад дэмжлэг үзүүлэх.

Зургаа. Удирдлага, зохион байгуулалт

6.1. Цогц арга хэмжээг удирдан зохион байгуулах үүрэг бүхий Зөвлөл (цаашид "Зөвлөл" гэх) ажиллана. Зөвлөлийн дарга нь гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна.

6.2. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Зөвлөлийн даргын тушаалаар батална. Зөвлөл нь гадаад харилцаа, боловсрол, шинжлэх ухаан, соёл, спорт, хөдөлмөр, нийгмийн хамгаалал, хууль зүй, хүнс, хөдөө аж ахуй, аялал жуулчлал болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, үндэсний хөгжил, улсын бүртгэл, гадаадын иргэн, харьят, хил хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, шинжлэх ухааны байгууллага, хилийн чанад дахь Монголчуудын холбоо, төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдэнэ.

6.3. Зөвлөл нь Цогц арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүр боловсруулж, Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулна.

6.4. Цогц арга хэмжээний хэрэгжилтийг Зөвлөл хариуцан зохион байгуулж, явц, үр дүнг Засгийн газарт хагас жил тутам танилцуулна.

6.5. Зөвлөл нь цогц арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг болох судалгаа, тайлан гаргах, нийтэд таниулан сурталчлах, хэрэгжилтэд хяналт тавих цахим мэдээллийн системийг хариуцан ажиллуулна.

Долоо. Санхүүжилтийн эх үүсвэр

7.1. Цогц арга хэмжээг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

7.1.1. шаардагдах хөрөнгийн 60 хувийг улсын төсвөөс;

7.1.2. шаардагдах хөрөнгийн 40 хувийг төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн хандив, тусlamжаас.

7.2. Улсын төсвөөс шаардагдах санхүүжилтийг жил бүрийн улсын төсөвт тусгуулна.

Найм. Шалгуур үзүүлэлт

8.1. Цогц арга хэмжээний хэрэгжилтийг дараах шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ:

8.1.1. хилийн чанад дахь Монгол Улсын иргэдийн эрх ашгийг хамгаалах, эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хүрсэн үр дүн;

8.1.2. хилийн чанад дахь Монгол Улсын иргэдийн нэгдсэн мэдээллийн санд бүртгэгдсэн иргэдийн тоо;

8.1.3. хилийн чанад дахь Монгол хэл, соёлын төвүүдэд эх хэл, соёл, түүхийн сургалтад хамрагдсан хүүхдийн тоо;

8.1.4. хилийн чанадад зохион байгуулагдсан монгол судлал, соёлын өвийн талаарх олон улс, бүс нутгийн арга хэмжээний тоо;

8.1.5. хилийн чанад дахь Монгол Улсын иргэд, Монголчуудын холбоодтой хамтран зохион байгуулсан, дэмжлэг үзүүлсэн арга хэмжээ, хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн тоо;

8.1.6. монгол хэлийг суралцагч хилийн чанад дахь иргэд, монгол туургатнууд, гадаадын иргэдийг хамруулсан сургалт, хөтөлбөрийн тоо;

8.1.7. монгол туургатнуудтай хамтран зохион байгуулсан, дэмжлэг үзүүлсэн арга хэмжээний тоо;

8.2. Зөвлөл шалгуур үзүүлэлт бүрээр хүрэх зорилтот үзүүлэлтийг жил бүр тогтооно.

Ес. Хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

9.1. Цогц арга хэмжээний хэрэгжилтийг зорилт, үйл ажиллагааны үр дүн, шалгуур үзүүлэлт, зорилтот үзүүлэлтээр үнэлнэ.

9.2. Цогц арга хэмжээний хэрэгжилтэд гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жил бүр аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.